

МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН
/Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/

2023.11.18

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан нөхцөл тайлбар)
				Он	Түвшин		
НЭГ.ГАЗРЫН ХАРИЛЦАА							
Зорилт 3.6. Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ:							
1	3.6.2. Хаягжилтын нэгдсэн системийг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулна.	Үйл ажиллагаа	Хаягийн мэдээлэлийн засвар сумын тоо, Ажлын гүйцэтгэлийн хувь	2021-2025	0 0	3 90	Аймгийн хэмжээнд 2017-2020 оны хооронд нийт 87.5 сая төгрөгийн төсвөөр 3652 ширхэг хаягийн тэмдэгийг хийлгэн байршуулсан. Гудамж, зам талбайг зураглах, нэгж талбар, барилгад хаяг олгох, засварлах ажлыг 2021 оноос эхлэн хаягийн мэдээллийн системээр дамжуулан олгож байгаа бөгөөд 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 12459 нэгж талбараас 11779 нэгж талбар буюу 94,5% нь, 2469 барилгаас 2469 барилга орж 100%-тай аймгийн хэмжээнд нийтдээ 97,25%-ийн биелэлттэй байна. Мөн үе шаттайгаар хаягийн мэдээллийн санд орц, гарцыг тодорхойлон ажиллаж байгаа бөгөөд 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 12459 нэгж талбараас 11129 нэгж талбар, 2469 барилгаас 2201 барилгын орц, гарцыг тодорхойлон 89,2%-ийн гүйцэтгэлтэй орц, гарцыг тодорхойлон ажилласан байна. Үүний үр дүнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдийн газрын хаяг дугаар давхардахгүй байх, нэгдсэн стандарт загвартай болсон зэрэг давуу талтай. Хүрсэн түвшин: Хаягийн тоо - 12459 Хэрэгжилт 100 хувь
2	3.6.3. Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлнэ.	БТ	Газрын мониторингийн цахим системд программ хангамжийг хөгжүүлнэ.	2021-2025	90	100	Газар ашиглалт, газрын мониторингийн цахим системийг 2020 оноос эхлэн хэрэглээнд нэвтрүүлэн үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж хэвшсэн. 2021 оны 10 дугаар сараас хөгжүүлэлт хийгдэж дуусан egazar.gov.mn сайтын газрын мониторингийн цахим системээр дамжуулан газрын захиалгат хянан баталгааны мэдэгдэх хуудсыг иргэн, аж ахуйн нэгжид олгох болон баталгаажсан тайлан дүгнэлтээ цахимаар авах боломжийг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд захиалгат хянан баталгаа хийлгэх шаардлагатай 1294 нэгж талбар байна. Үүнд: - Сүмбэр суманд- 984 нэгж талбар

							- Баянтал суманд- 112 нэгж талбар - Шивээговь суманд- 198 нэгж талбар байна. Судалгааны үр дүнд 903 нэгж талбарт захиалгат хянан баталгааг хийлгэх мэдэгдэх хуудас хүргүүлж, өссөн дүнгээр 2023 оны жилийн эцсийн байдлаар 300 нэгж талбарын газрын захиалгат хянан баталгааг цахимаар ирүүлснийг баталгаажуулаад байна. Үр дүн: Иргэн, аж ахуйн байгууллага egazar.gov.mn сайтыг ашиглан Газрын мониторингийн цахим системээр дамжуулан Газрын захиалгат хянан баталгааг нээлттэй ил тод цахимаар ирүүлж цаг хугацаа, эдийн засаг хэмнэх боломж бүрдээд байна. Хэрэгжилт 100 хувь
3	3.6.4. Монгол Улсын геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулж, нийт нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын байр зүйн зургаар бүрэн хангана.	ОНТ	Геодезийн солбицлын ITRF2020 тогтолцоонд шилжүүлэх	2023-2025	-	-	Монгол улсын Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай” тогтоолоор батлагдан Геодезийн солбицлын ITRF2020 тогтолцоонд шилжсэнтэй холбогдуулан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд шаардагдах 290.5 сая төгрөгийн аймгийн төвийн сум буюу Сүмбэр сумын суурьшлын хэсгийн 1:1000 масштабтай байр зүйн зураг, газар доорхи инженерийн шугам сүлжээний зургийг ITRF2020 эринд шинээр хийх зардлыг 2024 оны аймгийн орон нутгийн төсөвт тусгуулахаар хагас жилээр аймгийн ЗДТГ-т мөн аймгийн Засаг даргад 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 01/349 тоот албан бичгээр тооцоо, судалгааны хамт хүргүүлэн ажилласан. Хэрэгжилт 90 хувь
4	3.6.5. Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ.	Үйл ажиллагаа	1. Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн нэгдсэн системийн үйл ажиллагааг орон нутагт явуулах, нэгж талбарт ногдуулалтыг үүсгэж, нэхэмжлэхийг татварын систем рүү илгээх. 2. Газрын биржийн үйл ажиллагааг орон нутагт явуулна.	2021-2025	1416 нэгж талбар	1436 2872	-Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татварын нэгдсэн системийг 2020 оноос нэвтрүүлж үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна. 2023 онд газрын төлбөрийн системээр дамжуулан Газрын кадастрын цахим системд бүртгэлтэй хүчинтэй гэрээг үндэслэн нийт 11240 нэгж талбарт татвар, төлбөрийн ногдуулалтыг үүсгэж татварын системд илгээж ажилласан. Үүнд: - 2115 нэгж талбарт газрын төлбөрийн ногдуулалт - 9125 нэгж талбарт газрын татварын ногдуулалт үүсгэсэн. Хүрсэн түвшин : Татварын хэлтэс нь газрын татвар, төлбөрийг үүсгэсэн нэхэмжлэхийн дагуу хураах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 оны 11 дүгээр сарын 13-ний байдлаар 298.716.873 төгрөгийг орон нутгийн оруулж 59.7 хувийн биелэлттэй байна. -Газрын биржийн үйл ажиллагаа 2015 оноос эхлэн үйл ажиллагаанд нэвтрүүлж ашиглаж хэвшсэн бөгөөд дуудлага худалдааг 100% цахимаар зохион байгуулан ажиллаж байна. 2023 оны “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-ний дагуу 12 байршлын 55,65 га талбайн

							дуудлага худалдааг Газрын биржийн mle.mn цахим системээр зохион байгуулан ажилласан. Үүнд: 1. • Сүмбэр суманд 11 байршил -/170.249.000 төгрөг/ 2. • Шивээговь суманд 1 байршил-/164.000.000 төгрөг/ газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зохион байгуулан холбогдох зар мэдээг “Зууны мэдээ” сонин болон www.mle.mn цахим сайт, байгууллагын пэйж хуудсаар мэдээ мэдээллийг тогтмол ил тод байршуулан ажилласан. Үр дүн : 12 байршилд дуудлага худалдаа зохион байуулагдаж 2023 оны 11 дүгээр сарын 13-ний өдрийн байдлаар 334,249,000 төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлээд байна. Мөн Сүмбэр суманд 2 байршилд дуудлага худалдааг зарлаж 12 дугаар сарын 14-нд зохион байгуулагдана. Хэрэгжилт 100 хувь
5	3.6.6. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг хийнэ.	Үйл ажиллагаа	-Хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох мэдээллээр хангасан байна. -Холбогдох талуудыг бүрэн хамруулсан байх. Ажлыг зохион байгуулахад холбогдох яам агентлагаас сургалт мэдээлэл авах.	2022	-	-	“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн төлөвлөлтийн танилцуулга, хэлэлцүүлэг 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр манай аймагт амжилттай зохион байгуулагдсан. Хэлэлцүүлэгийг Барилгын хөгжлийн төвийн Бүс нутаг, хот суурины төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Даваанямаар ахлуулсан ажлын хэсэг орон нутгийн ажлын хэсэгтэй хамтран ажиллаж “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн төлөвлөлтийн шийдэл” сэдвээр илтгэл танилцуулж 150 гаруй хүн хамрагдсан. Үүний үр дүнд Чойр хотын ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох бодлогын баримт бичиг болосруулахад иргэдээс санал авч, мэдээлэл солилцсон. Хэрэгжилт 100 хувь
Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем)							
	5.3.4. Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал нэмэгдэж, иргэд, олон						Төрийн үйлчилгээг цахимжуулж, иргэд олон нийт интернеттэй газраас цахимаар үйлчилгээ авах, санал хүсэлтээ өгөх боломжийг дараах системүүдээр дамжуулан хэрэгжүүлж хэвшиж байна. - Газрын удирдлагын цахим системүүд /8 төрлийн/ -egazar.gov.mn -geoportal.gov.mn -MLE.mn -urban.gov.mn веб системүүдээс гадна киоск машинаар дамжуулан төрийн үйлчилгээг цахимжуулан ажиллаж байна. 2023 оны байдлаар 57 төрлийн үйлчилгээг цахим системүүдээрээ үзүүлж байна. Үүнээс гадна e-mongolia төрийн нэгдсэн цахим системээр дамжуулан газартай холбоотой 17 төрлийн лавлагааг олгон ажиллаж байна.

6	нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлнэ.						Мөн байгууллагын цахим хуудас болон өдөр тутмын “Зууны мэдээ” сонингоор дамжуулан иргэд олон нийтэд зар мэдээллийг ил тод нээлттэй хүргэн ажиллаж байна. Мөн дараах ажлуудыг олон нийтээр цахимаар болон биечлэн, цаасаар санал авч ажилласан. Үүнд: -Газрын төлбөрийн итгэлцүүрийн хувь хэмжээ -Багийн оноосон нэрийн санал -Багийн хил заагийн санал -Орон сууцны эрэлт хэрэгцээний судалгааг цахимаар олон нийтээс авч ажилласан. Хэрэгжилт 100%
Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба							
7	5.4.1. Чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн алба төлөвшүүлнэ.						Манай байгууллагын албан хаагчид тогтвортой, мэргэшиж ажиллаж байгаа бөгөөд нийт албан хаагчдын 11 албан хаагч нь 5 буюу түүнээс дээш жил ажиллаж байгаа, 6 албан хаагч 5-аас доош жил ажиллаж байна. Мөн 7 ажилтан мэргэшсэн зэрэгтэй инженер, ажилтан байна. -Албан хаагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх зорилгоор байгууллага дотооддоо төлөвлөгөө гарган сургалтыг зохион байгуулж хэвшсэн. ➢ Байгууллагын дотоод сургалтыг 1,2,3,4 дүгээр улиралд нийт 40 сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулласан. ➢ Ажил мэргэжлийн чиглэлээр чадавхижуулах зорилгоор болон бусад чиглэлүүдээр дараах сургалтуудад хамрагдсан байна. Үүнд: 1. ГЗБГЗЗГ аас зохион байгуулсан сургалтанд давхардсан тоогоор 38 албан хаагч 2. Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн 4 дэхь өдөр зохион байгуулсан 10 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 120 албан хаагч; 3. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны цахим, танхим хосолсон сургалтад 13 албан хаагч хамрагдаж, сертификат авсан. 4. Бусад холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан сургалтуудад албан хаагчид тухай бүр хамрагдаж мэдлэг чадвараа ахиулан ажиллаж байна. Үүний үр дүнд албан хаагчдын мэдлэг чадвар сайжирч, иргэн, хуулийн этгээдэд мэдээ мэдээлэлийг үнэн зөв бодитой түргэн

						шуурхай хүргэх, багаар ажиллах чадвар сайжрах зэрэг олон давуу талууд бий болсон байна. Хэрэгжилт 100%
8	5.4.2. Сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн албан хаагч тогтвортой ажиллах нөхцөл бүрдэж, төрийн албаны шатлан дэвшүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.	-	Тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдын тоо	2022	-	Байгууллагад 17 албан хаагч ажилладаг бөгөөд албан хаагчид харьцангуй маш тогтвор суурьшилтай ажиллаж байна. Үүнд: ✓ 10-с дээш жил- 8 албан хаагч ✓ 5-с дээш жил- 3 албан хаагч ✓ 3-с дээш жил- 1 албан хаагч ✓ 0-1-с дээш жил- 5 албан хаагч тус тус ажилласан байна. Үүний үр дүнд байгууллагын үйл ажиллагаа тогтвортой, мэргэшсэн, чадварлаг албан хаагчдыг бүрдүүлэхээс гадна албан хаагчид өсөн дэвжих боломж нь нэмэгдэж байна. Хэрэгжилт 100%
9	5.4.3. Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.	-	Ёс зүйн зөвлөл байгуулж, албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх	2022	-	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-г байгууллагын даргын 2023 оны А/12 дугаар тушаалаар шинэчлэн баталж 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг зохион байгуулсан. - Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гарган байгууллагын даргад танилцуулж ажилласан - Албан хаагчдад анхааруулах 6 заалт бүхий зөвлөмж чиглэлийг өгч ажилласан. - Мөн шинээр ажилд орсон албан хаагчдад дотоод журам, ёс зүйн дүрэм зэрэг дүрэм журмуудтай танилцуулан гарын үсэг зуруулсан - Байгууллагын Ёс зүйн зөвлөлөөс албан хаагчдад 2 удаа танхимаар сургалт зохион байгуулахаас гадна цахим группээр дамжуулан 5 удаа зөвлөмж, мэдээлэл өгч ажилласан. Үүний үр дүнд албан хаагчид ёс зүйн зөрчил дутагдлын талаар мэдлэг мэдээлэлтэй болж урьдчилан сэргийлж чадаж байна. Хэрэгжилт-100%
10	5.4.4. Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлнэ.	Үйл ажиллагаа	Албан хаагчдыг сургалтад хамруулж, сурч хөгжих боломжийг бүрдүүлэх.	2022	-	-Албан хаагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх зорилгоор байгууллага дотооддоо төлөвлөгөө гарган сургалтыг зохион байгуулж хэвшсэн. ➢ Байгууллагын дотоод сургалтыг 1,2,3,4 дүгээр улиралд нийт 40 сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулласан.

						➤ Ажил мэргэжлийн чиглэлээр чадавхижуулах зорилгоор болон бусад чиглэлүүдээр дараах сургалтуудад хамрагдсан байна. Үүнд: 5. ГЗБГЗЗГ аас зохион байгуулсан сургалтанд давхардсан тоогоор 38 албан хаагч 6. Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн 4 дэхь өдөр зохион байгуулсан 10 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 120 албан хаагч; 7. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны цахим, танхим хосолсон сургалтад 13 албан хаагч хамрагдаж, сертификат авсан. 8. Бусад холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан сургалтуудад албан хаагчид тухай бүр хамрагдаж мэдлэг чадвараа ахиулан ажиллаж байна. Үүний үр дүнд албан хаагчдын мэдлэг чадвар сайжирч, иргэн, хуулийн этгээдэд мэдээ мэдээлэлийг үнэн зөв бодитой түргэн шуурхай хүргэх, багаар ажиллах чадвар сайжрах зэрэг олон давуу талууд бий болсон байна. Хэрэгжилт 100%
11	5.4.5. Төрийн үйлчилгээний чанарын стандарт бий болж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлнэ.	Үйл ажиллагаа	Мэдээллийн ил тод байдал	2022	-	Хэрэгжилт ийг хангах ажиллах Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулж, иргэд, олон нийт цахимаар хяналт тавих нөхцөл бололцоог бүдүүлэн 2023 оны байдлаар байгууллагын сайтанд нийт 253 зар, мэдээ, мэдээлэл, тайлан байршуулсан байна.Үүнд - Байгууллагын үйл ажиллагаатай холбогдон гарсан тушаал шийдвэр 17, - Сар бүр хийсэн ажлуудын тайлан 10 удаа - Газрын харилцааны чиглэлээрх мэдээлэл 99 - Барилга, хот байгуулалттай холбогдолтой 38 - Өргөдөл, гомдол шийдвэрлэлт 3 - Байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүүтэй холбоотой 86 мэдээ, мэдээллийг тус тус байршуулсан байна. Үүнээс гадна байгууллагын пэйж хуудсаар мэдээ мэдээллийг тухай бүр нь байршуулан ажиллаж байна. Мөн мэдээллийг тогтмол график үзүүлэлт, тоон мэдээлэл, зурган мэдээлэл, статистик үзүүлэлтээр гарган оруулж хэвшсэн.

						Мэдээллүүдийг цахим хуудсанд байршуулахдаа иргэд томруулж харах, хэвлэж авах болон татаж авах боломжтойгоор байршуулж хэвшсэн. Үүний үр дүнд иргэд төрийн үйлчилгээг авахад илүү хялбар, шат дамжлага бага, явдал чирэгдэл багатайгаар хүртэх боломжийг бүрдүүлж байгаа юм. Хэрэгжилт 100%
12	5.4.6. Төрийн үйл ажиллагааны бүхий л шатанд Шилэн дансны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах замаар иргэдийн мэдээлэл авах эрхийг дээдлэн ажиллаж, холбогдох хуулийн дагуу иргэний шаардсан мэдээллийг гаргаж өгөөгүй төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын удирдлагад хариуцлага тооцдог болно.	Үйл ажиллагаа	1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал 2. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах тухай хуульд заасан мэдээллийн ил, тод нээлттэй байдал	2022	-	Хэрэгжилтийг хангаж ажиллах www.shilendans.gov.mn сайтанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн мэдээллийг хуулийн хугацаанд нь нийт 141 ш мэдээллийг бүрэн байршуулан ажилласан. Үүнд: ✓ Сар бүр цэсэнд 40ш ✓ Хагас жил бүр цэсэнд 4ш ✓ Жил бүр цэсэнд 5ш Тухай бүр цэсэнд 92ш мэдээллийг тус тус байршуулж мэдээлсэн. Газартай холбоотой 17 төрлийн лавлагааг E-mongolia цахим системийг ашиглан авах боломжтой болсон. Үүнд: • Газар эзэмших эрхийн гэрчилгээний лавлагаа; • Газар эзэмших эрхийн лавлагаа; • Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн шүүхийн шийдвэртэй эсэх лавлагаа; • Газрын кадастрын нэгж талбарын тодорхойлолт; • Газрын төлбөр, тооцоо нийлсэн акт; • Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээний лавлагаа; • Кадастрын зураг хэвлэж авах; • Нэгж талбарын дуудлага худалдааны анхны үнийн лавлагаа; • Нэгж талбарын үнэлгээний лавлагаа; • Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газар эзэмших, ашиглах, өмчлөх саналаа өгөх; • Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зураг, тайлан харах • Барилга байгууламжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх • Газар олголтын баримтын хуулбар • Инженерийн шугам сүлжээнд холбогдсон эсэх лавлагаа

						• Хүн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээний лавлагаа • Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа • Үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа болон шилжүүлсэн тухай лавлагаа Үр дүнд: Газартай холбоотой 17 төрлийн лавлагаа үйлчилгээ E-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэмэгдсэнээр иргэн, хуулийн этгээд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хаанаас ч өөрийн эзэмшил газрын лавлагаа үйлчилгээг E-mongolia авах боломжтой юм. Хэрэгжилт 100%
Авлигагүй засаглал						
13	5.6.1.нийгмийн бүх түвшинд шударга ёсыг бэхжүүлэх бодлогын болон хууль, эрх зүйн орчин бүрдэнэ.					-Байгууллагын 2023 оны авлигын эсрэг төлөвлөгөөг нийт 16 арга хэмжээтэйгээр төлөвлөн газрын даргаар батлуулсны дагуу хэрэгжилтийг ханган ажилласан. Хагас жилийн хэрэгжилтийг гарган байгууллагын цахим хуудасны ил тод цэсний Авлига ашиг сонирхол цэсэнд төлөвлөгөөний хамт байршуулсан. 2023 оны Аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах тухай заалтыг тусган хэрэгжилтийг хангаж, иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх хөтөлбөр арга хэмжээнд манай байгууллага оролцсон. Хэрэгжилт-100%
15	5.6.3.төрийн бүх шатанд авлигыг таслан зогсоох хөтөлбөр хэрэгжүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.			2022		Авлигатай тэмцэх газраас явуулж байгаа видео бичлэг, танилцуулгаас 2023 онд нийт 7 мэдээллийг байгууллагын фэйсбүүк пэйж “Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар” хуудсаар орон нутгийн Чойр зар, Говьсүмбэр гэсэн цахим зарын фэйсбүүк хаягаар иргэд, олон нийтэд түгээсэн. 2023 оны 06 дугаар сарын 09 өдөр Авлигын эсрэг НЭГДЬЕ сурталчилгааны материалыг хуваарилсан гадна мэдээллийн самбарт байршуулсан. -2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Авлигын эсрэг хуулийг сурталчлан таниулах, авлигын эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан сургалтанд Газрын дарга, нэгжийн дарга нар болон улсын байцаагчид хамрагдсан.

							-Аймгийн Засаг даргын Тамгын газраас 2023 оны 11 дүгээр сарын 20-21-ний өдрүүд зохион байгуулсан Карл Попперын мэтгэлцээнд 1 албан хаагч оролцсон. Үүний үр дүнд албан хаагчид авлигаас ангид байж, ямар нэгэн зөрчил бүртгэгдээгүй.. Хэрэгжилт-100%
--	--	--	--	--	--	--	---

БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

№	Арга хэмжээний тоо	Үүнээс:						Үнэлэх боломжгүй	Биелэлтийн хувь
		Хэрэгжих шатандаа							
		100%	90%	70%	50%	30%	0%		
1	14	12	2	-	-	-	-	-	98,5

ХЯНАСАН: ГАЗРЫН ДАРГА
ТАЙЛАН НЭГТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН

Б.ОТГОНЧИМЭГ
Т.УРАНТОГОС